



**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

299.	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай	1281
300.	Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай	1294
301.	Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1294
302.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1295
303.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1295
304.	Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт оруулах тухай	1296
305.	Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай	1296
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>		
306.	Үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 154 1308

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2013 оны 07 дугаар  
срын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ  
ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход оршино.



## **2 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль тогтоомж**

2.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

## **3 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны зарчим**

3.1.Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна дараах үндсэн зарчмыг баримтална:

- 3.1.1.хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
- 3.1.2.нууцлалыг хамгаалах;
- 3.1.3.шуурхай байх;
- 3.1.4.хамтран ажиллах.

3.2.Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа нь хамгаалалтад байгаа хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус, хэрцгий хандах явдлаас ангид байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хязгаарлахгүй.

3.3.Хамгаалалтад байгаа хүн мэдээллээр хангагдах, мэдээлэл задрахаас хамгаалагдах, өмч болон ажлын байраа хадгалуулах эрхтэй.

## **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."гэрч, хохирогч" гэж Эрүүгийн байцаан шийтгэх хуульд<sup>2</sup> заасан гэрч, хохирогчийг;

4.1.2."хамгаалалтын арга хэмжээ" гэж энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг;

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Эрүүгийн байцаан шийтгэх хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.



4.1.3."эрх бүхий албан тушаалтан" гэж энэ хуульд заасан гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтныг /шүүгч, прокурор, мөрдөгч, Тахарын албаны алба хаагч/.

## **5 дугаар зүйл.Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд**

5.1.Энэ хуулийн зохицуулалтад гэрч, хохирогч хамаарна.

5.2.Шаардлагатай гэж үзвэл гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээдийг энэ хуулийн зохицуулалтад хамааруулж болно.

5.3.Энэ хуулийн 5.2-т заасан гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээд гэж тэдгээрийн нөхөр /эхнэр/, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охиныг ойлгоно.

5.4.Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн энэ хуульд хамаарагдаж болно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ, ТУСЛАЛЦАА**

### **6 дугаар зүйл.Хамгаалалтын арга хэмжээний төрөл**

6.1.Хамгаалалтын арга хэмжээ нь дараах төрөлтэй байна:

- 6.1.1.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ;
- 6.1.2.сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ.

### **7 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ**

7.1.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна:

- 7.1.1.урьдчилан сануулах;
- 7.1.2.тодорхой үйлдлийг хязгаарлах;
- 7.1.3.биечилсэн хамгаалалт;
- 7.1.4.мэдээллийн нууцлалыг хангах;
- 7.1.5.нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах;



- 7.1.6. аюулгүй газарт түр байрлуулах;
- 7.1.7. нүүлгэн шилжүүлэх;
- 7.1.8. баримт бичгийг солих;
- 7.1.9. гадаад төрхийг өөрчлөх.

7.2. Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7.3. Энэ хуулийн 7.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сонгож хэрэглэнэ.

## **8 дугаар зүйл. Урьдчилан сануулах**

8.1. Гэрч, хохирогчийг алах, бие махбодид гэмтэл учруулах, тарчлаах, айлган сүрдүүлэх, дарамтлах, мөнгө, эд зүйл амлах болон бусад гэмт хэргийг үйлдэхээр заналхийлсэн нь тогтоогдвол тухайн этгээдэд хүлээлгэх ял шийтгэлийн талаар шүүгч, прокурор, мөрдөгч, Тахарын албаны алба хаагч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

## **9 дүгээр зүйл. Тодорхой үйлдлийг хязгаарлах**

9.1. Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээнд гэрч, хохирогчтой уулзах, харилцах, харилцаа тогтоохыг оролдох, дагаж мөшгих болон бусад хэлбэрээр харилцахыг хориглох арга хэмжээ хамаарна.

9.2. Тодорхой үйлдлийг хязгаарлах арга хэмжээ авсан эрх бүхий албан тушаалтан хязгаарлах арга хэмжээ авахуулсан этгээдээр гарын үсэг зуруулж, түүнд хяналт тавина.

## **10 дугаар зүйл. Биечилсэн хамгаалалт**

10.1. Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор биечилсэн хамгаалалтад авна.

10.2. Энэ хуулийн 10.1-д заасан хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно.

## **11 дүгээр зүйл. Мэдээллийн нууцлалыг хангах**

11.1. Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар



зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд халхавч нэр хэрэглэх, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөрчлөх зэрэг арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

11.2.Эрх бүхий албан тушаалтан иргэний бүртгэлийн, автотээврийн болон бусад байгууллагын мэдээлэл, лавлагааны сангаас хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн хувийн мэдээллийг задруулахыг түр хугацаагаар хориглох шийдвэр гаргаж болно.

11.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой онцгой тохиолдолд, эсхүл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх явцад хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн талаарх мэдээлэл авах хүсэлтээ Үндсэн хуулийн цэц болон шүүх эрх бүхий байгууллагад бичгээр гаргана.

### **12 дугаар зүйл.Хувийн хамгаалалтын хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах**

12.1.Гэрч, хохирогчийг Хувийн хамгаалалтын тухай хуулийн<sup>3</sup> 12.1-д заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай тохиолдолд түүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.

12.2.Тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **13 дугаар зүйл.Аюулгүй газарт түр байрлуулах**

13.1.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.

### **14 дүгээр зүйл.Нүүлгэн шилжүүлэх**

14.1.Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюул, заналхийлэл бодитой болох нь тогтоогдвол түүнийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлнэ.

<sup>3</sup>Хувийн хамгаалалтын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2001 оны 25 дугаарт нийтлэгдсэн.



14.2.Гэрч, хохирогчийг оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлэхэд түүний болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн ажил, сургууль, амьдрах орон байр болон шаардлагатай бусад асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно.

### **15 дугаар зүйл.Баримт бичгийг солих**

15.1.Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн иргэний бүртгэлд өөрчлөлт оруулж, баримт бичгийг солино.

15.2.Гэрч, хохирогчийн баримт бичгийг солих аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд дараах баримт бичгийн өөрчлөлт хамаарна:

15.2.1.иргэний болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, гадаад паспорт, гэрлэлтийн баталгаа, диплом болон бүх төрлийн зөвшөөрөл зэрэг албаны баримт бичиг;

15.2.2.эрүүл мэндийн болон нийгмийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, цэргийн бүртгэл, эдгээртэй адилтгах нийгмийн хамгаалал, халамжтай холбоотой бусад баримт бичиг;

15.2.3.хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрхийн гэрчилгээ;

15.2.4.шаардлагатай бусад баримт бичиг.

15.3.Гэрч, хохирогч овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээ өөрчлөх тохиолдолд урьд өмнө гүйцэтгээгүй байгаа үүргийнхээ талаар эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй ба ийнхүү мэдэгдээгүйгээс үүсэх үр дагаврыг Засгийн газар хариуцахгүй.

### **16 дугаар зүйл.Гадаад төрхийг өөрчлөх**

16.1.Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалалтын өөр арга хэмжээгээр хангах боломжгүй тохиолдолд түүний зөвшөөрснөөр гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчилж болно.

16.2.Гэрч, хохирогчийн гадаад төрхийг мэс заслын бус аргаар өөрчлөх /үс засалт, үс, нүдний өнгийг өөрчлөх гэх мэт/ хамгаалалтын арга хэмжээ авч болно.

16.3.Энэ хуулийн 16.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг насанд хүрээгүй гэрч, хохирогчид хэрэглэхгүй.



16.4.Энэ хуулийн 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх бол тухайн гэрч, хохирогчийн гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаарх лавлагааг холбогдох байгууллагаас авна.

### **17 дугаар зүйл.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ**

17.1.Энэ хуулийн 5.1-д заасан гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ авна.

17.2.Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээнд дараах арга хэмжээ хамаарна:

17.2.1.гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах;

17.2.2.гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;

17.2.3.шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх;

17.2.4.шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг хамт байлцуулах;

17.2.5.шаардлагатай бусад арга хэмжээ.

17.3.Энэ хуулийн 23.4-т заасан сэтгэл зүйчийн баг хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### **18 дугаар зүйл.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид үзүүлэх туслалцаа**

18.1.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид дараах туслалцаа үзүүлж болно:

18.1.1.хууль зүйн туслалцаа;

18.1.2.сэтгэл зүйн туслалцаа;

18.1.3.эрүүл мэндийн туслалцаа.

18.2.Гэрч, хохирогчид энэ хуулийн 18.1.1, 18.1.2-т заасан туслалцаа болон гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон бол эрүүл мэндийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлнэ.



18.3.Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

18.4.Энэ хуулийн 18.1.1-д заасан хууль зүйн болон 18.1.2-т заасан сэтгэл зүйн туслалцааг энэ хуулийн 23.4-т заасан нэгж тус тус хариуцан хэрэгжүүлнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ**

### **19 дүгээр зүйл.Хамгаалуулах эрх үүсэх**

19.1.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл хохирол учирсан бол хамгаалуулах эрх үүснэ.

### **20 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх, цуцлах үндэслэл**

20.1.Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх үндэслэл нь гэрч, хохирогчийн хүсэлт, эсхүл өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн бичгээр гаргасан санал байна.

20.2.Аюулгүй байдлын хамгаалалтыг дараах үндэслэлээр цуцална:

20.2.1.хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн бичгээр гаргасан хүсэлт;

20.2.2.аюулгүй байдлын хамгаалалт хэрэглэх шийдвэр гаргасан албан тушаалтан, эсхүл түүний дээд шатны албан тушаалтны шийдвэр.

20.3.Энэ хуулийн 20.2.2-т заасан албан тушаалтан дараах үндэслэлээр аюулгүй байдлын хамгаалалтыг цуцлах шийдвэр гаргана:

20.3.1.гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нөхцөл байдал арилсан;

20.3.2.хамгаалуулагч нь аюулгүй байдлын хамгаалалтын шаардлага, арга хэмжээг санаатайгаар удаа дараа зөрчсөн.



## **21 дүгээр зүйл. Аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх журам**

21.1. Эрх бүхий албан тушаалтан гэрч, хохирогчийн хүсэлт, зөвшөөрөл, бодит аюул заналхийллийн талаарх баримтыг үндэслэн энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөлд дүн шинжилгээ хийх замаар аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг нэн даруй гаргана.

21.2. Дараах албан тушаалтан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана:

21.2.1. Энэ хуулийн 16.2-т заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг хамгаалалтад байгаа гэрч, хохирогч, эсхүл түүний өмгөөлөгчийн хүсэлтээр Тахарын албаны алба хаагч;

21.2.2. Энэ хуулийн 7.1.2-7.1.6-д заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг мөрдөн шалгах ажиллагаанд прокурор, шүүхийн шатанд шүүгч;

21.2.3. Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг прокурор, мөрдөн шалгах болон тагнуулын байгууллагын гаргасан саналыг үндэслэн шүүгч.

21.3. Энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан арга хэмжээ нь аюулгүй байдлын онцгой арга хэмжээ бөгөөд эдгээрийг Мөрдөх албаны харьяалах хэргийн гэрч, хохирогчид тэдний аюулгүй байдлыг хамгаалалтын бусад арга хэмжээг хэрэглэн хамгаалж чадахгүй нөхцөлд хэрэглэнэ.

21.4. Энэ хуулийн 7.1.6-7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх явцад тухайн хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийг өмнө ажиллаж байсантай ижил хэмжээний цалин хөлс бүхий ажлын байраар хангана. Хэрэв ийм боломжгүй бол өмнө авч байсан дундаж цалин хөлстэй нь тэнцэх нөхөн олговрыг хамгаалалтад байх хугацаанд олгоно.

21.5. Энэ хуулийн 7.1.3-7.1.9-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.6. Энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээний талаар мэдсэн иргэн, албан тушаалтан бусдад энэхүү мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.



21.7.Энэ хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад авах бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг ажиллагаа дууссаны дараа үргэлжлүүлж болно.

## **22 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргахад харгалзан үзэх нөхцөл**

22.1.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргахдаа эрх бүхий албан тушаалтан дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

22.1.1.гэрч, хохирогчийн аюулгүй байдалд учирч болох эрсдэл;

22.1.2.хамгаалалтад авснаар олон нийтэд учирч болох эрсдэл;

22.1.3.гэрч, хохирогчийн өгсөн, өгөхөөр зөвшөөрсөн мэдээлэл, нотлох баримтын ач холбогдол;

22.1.4.нөхцөл байдлын үнэлгээ, аюулын эрсдэлийн түвшин;

22.1.5.хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал;

22.1.6.хамгаалах арга хэмжээ хэрэглэх эсэхийг тодорхойлох сэтгэл зүйн сорилын үр дүн;

22.1.7.бусад нөхцөл.

22.2.Энэ хуулийн 23.4-т заасан сэтгэл зүйчийн баг нь шаардлагатай тохиолдолд хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлох зорилгоор энэ хуулийн 22.1.6-д заасан сэтгэл зүйн сорилыг авч, хамгаалалтын хэлбэрийг сонгох зөвлөмж гаргана.

## **23 дугаар зүйл.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, түүний үүрэг**

23.1.Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг дараах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ:

23.1.1.цагдаагийн алба;

23.1.2.мөрдөх алба;

23.1.3.Тахарын алба;

23.1.4.Авлигатай тэмцэх газар;



### 23.1.5. Тагнуулын ерөнхий газар.

23.2. Тахарын алба нь гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай нэгжтэй байна.

23.3. Тахарын алба нь гэрч, хохирогчийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

23.3.1. гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг шуурхай авах;

23.3.2. гэрч, хохирогчийг мэдээллээр хангах;

23.3.3. нүүлгэн шилжүүлэх, баримт бичиг солих, мэс заслын аргаар гадаад төрхийг өөрчлөх хамгаалалтын арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

23.3.4. шинээр ажилд ороход туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах;

23.3.5. хууль зүйн туслалцаа болон бусад нийгмийн үйлчилгээ үзүүлэх;

23.3.6. шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдлын хамгаалалтын хэлбэрийг өөрчлөх тухай саналаа холбогдох албан тушаалтанд гаргах;

23.3.7. энэ хуулийн 5.3-т заасан гэрч, хохирогчийн хамаарал бүхий этгээдийг хамгаалах, энэ хуульд заасан туслалцаа үзүүлэх;

23.3.8. хамгаалалтын үйл ажиллагааны нууцлалыг хангах;

23.3.9. шаардлагатай бусад.

23.4. Тахарын албаны хамгаалалтын тусгай нэгжийн дэргэд мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйчийн баг ажиллана.

23.5. Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар энэ хуулийн 7.1.1-7.1.6-д заасан арга хэмжээг өөрийн харьяалах асуудлын хүрээнд хэрэгжүүлнэ.



## **24 дүгээр зүйл.Хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах**

24.1.Хамгаалалтад байгаа гэрч, хохирогч энэ хуулийн 21.2-т заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй бөгөөд шийдвэрийг танилцуулснаас хойш 14 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргана.

24.2.Шүүх гомдлыг ажлын таван өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **25 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хүлээх үүрэг**

25.1.Засгийн газар гэрч, хохирогчийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

25.1.1.гэрч, хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх талаар хөтөлбөр баталж хэрэгжүүлэх;

25.1.2.гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээний зардлыг улсын төсвийн төсөлд тусгах.

25.2.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрч, хохирогчийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

25.2.1.гэрч, хохирогчийг хамгаалах талаар гадаад улстай хэлэлцээр хийх, гэрээ байгуулах;

25.2.2.энэ хуулийн 25.1.1-д заасан хөтөлбөрийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх ажлыг уялдуулан зохицуулах.

25.3.Шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хамгаалалтад байгаа болон хамгаалалтад байсан гэрч, хохирогчийг хамгаалах зорилгоор Тахарын албыг дараах мэдээллээр шуурхай хангах үүрэгтэй:

25.3.1.яллагдагчид авсан, өөрчилсөн таслан сэргийлэх арга хэмжээний талаар;



25.3.2. өршөөсөн, уучилсан шийдвэрийн талаар;

25.3.3. сулласан, хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон талаар;

25.3.4. ялтан хорих байгууллагаас түр болон бүрмөсөн чөлөөлөгдсөн талаар.

25.4. Шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гэрч, хохирогчтой харьцах, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр шүүгч, прокурор, мөрдөгчийг чадвар сайжруулах сургалтад хамруулж, хохирогч, гэрчтэй харьцахад баримтлах журам боловсруулж, мөрдүүлнэ.

25.5. Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага нь гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр Тахарын алба болон эрх бүхий бусад байгууллагад туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

25.6. Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан болон уг шийдвэрийг хэрэгжүүлж байгаа албан тушаалтан хохирогч, гэрчийн хувийн байдлын тухай мэдээллийг задруулахыг хориглоно.

## **26 дугаар зүйл. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох**

26.1. Гэмт хэргийн хохирогчид Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн<sup>4</sup> 21<sup>3</sup> дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгоно.

## **27 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

27.1. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль тогтоомжийг зөрчсөн хүнд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## **28 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

28.1. Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

<sup>4</sup>Засгийн газрын тусгай сангийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар  
срын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн албаны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг:**

“22.5.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалах арга хэмжээнд хамрагдсан албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно.”

#### **2/23 дугаар зүйлийн 23.3.4 дэх заалт:**

“23.3.4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 07 дугаар  
срын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 35.1.8 дахь заалт нэмсүгэй:

“35.1.8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан.”



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2013 оны 07 дугаар  
срын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“130.5.Ялтан суллагдвал энэ тухай Тахарын албанд мэдэгдэнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2013 оны 07 дугаар  
срын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ  
САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>3</sup> дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 21<sup>3</sup>.10 дахь хэсэг нэмсүгэй:

“21<sup>3</sup>.10.Гэмт хэргийн улмаас Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул учирсан бол энэ хуулийн 21<sup>3</sup>.2.1-д заасан эмчилгээний зардлыг шүүхийн шийдвэр гарсан эсэхээс үл хамааран нэн даруй олгож, буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.”



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2013 оны 07 дугаар  
срын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Тав дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 60 дахь заалт нэмсүгэй:

60	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээг хэрэглэх журам, арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл	нууцалсан зэрэглэлээр	байнга
----	--	-----------------------	--------

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2013 оны 07 дугаар  
срын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ЯЛЛАГДАГЧИД  
ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.**Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төлбөрийн чадваргүй яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцаа



үзүүлэх тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тогтооход оршино.

## **2 дугаар зүйл.Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль тогтоомж**

2.1.Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль<sup>2</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

## **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцаа” /цаашид “хууль зүйн туслалцаа” гэх/ гэж төлбөрийн чадваргүй яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор улсын өмгөөлөгчөөс үзүүлж байгаа хууль зүйн зөвлөгөө болон өмгөөллийн үйлчилгээг;

3.1.2.“төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн зөвлөгөө өгөх” гэж хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр лавлагаа, мэдээлэл өгөх, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулж туслахыг;

3.1.3.“төлбөрийн чадваргүй яллагдагчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх” гэж гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар мөрдөх ажиллагаа болон гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр оролцохыг;

3.1.4.“улсын өмгөөлөгч” гэж төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх үндсэн үүрэг бүхий, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн, Хууль зүйн туслалцааны төвийн хуульчийг;

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 11 дугаарт нийтлэгдсэн.



3.1.5. “төлбөрийн чадваргүй яллагдагч” гэж энэ хуулийн 7.1-д заасан хүнийг;

3.1.6. “хууль зүйн туслалцааны төв” /цаашид “Төв” гэх/ гэж төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллагыг.

#### **4 дүгээр зүйл. Хууль зүйн туслалцааны зарчим**

4.1. Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:

4.1.1. хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

4.1.2. шуурхай, бүрэн, тууштай байх;

4.1.3. нууцыг чанд хадгалах.

#### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА**

#### **5 дугаар зүйл. Хууль зүйн туслалцааны төрөл**

5.1. Хууль зүйн туслалцаа нь дараах төрөлтэй байна:

5.1.1. хууль зүйн зөвлөгөө өгөх;

5.1.2. өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх.

#### **6 дугаар зүйл. Хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүн**

6.1. Хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүн /цаашид “үйлчлүүлэгч” гэх/ нь төлбөрийн чадваргүй яллагдагч байна.

#### **7 дугаар зүйл. Яллагдагчийн төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлох**

7.1. Төлбөрийн чадваргүй яллагдагчид гэмт хэрэгт холбогдсон дараах хүн хамаарна:

7.1.1. Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүн;



7.1.2.энэ хуулийн 7.1.1-д заасан нэгдсэн санд бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болохоо тодорхойлсон хүн;

7.1.3.Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан онцгой болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд.

7.2.Энэ хуулийн 7.1.2-т заасан хүн нь төлбөрийн чадваргүй болохоо өөрөө тодорхойлно.

7.3.Улсын өмгөөлөгч нь хууль зүйн туслалцаа авахыг хүссэн үйлчлүүлэгчид төлбөрийн чадваргүй болохоо худал тодорхойлсон тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг урьдчилан бичгээр сануулна.

7.4.Энэ хуулийн 7.1-д заасан үйлчлүүлэгчийн төлбөрийн чадваргүй болохоо тодорхойлох өргөдлийн загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.5.Улсын өмгөөлөгч хууль зүйн туслалцаа үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн төлбөрийн чадваргүй эсэхэд эргэлзээ төрвөл төлбөрийн чадваргүй болохоо тодорхойлсон өргөдөлд заасан нөхцөлийг шалгаж, төлбөрийн чадвартай болох нь тогтоогдвол хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэрийг бичгээр гаргаж, хувийг үйлчлүүлэгчид өгнө.

7.6.Энэ хуулийн 7.5-д заасан хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан шийдвэр гаргахтай холбоотой харилцааг Төвийн дүрмээр зохицуулна.

7.7.Улсын өмгөөлөгч нь төлбөрийн чадваргүй болохоо тодорхойлох өргөдлийн мэдээллийг шалгах зорилгоор холбогдох байгууллагаас лавлагаа авах эрхтэй бөгөөд тухайн байгууллага энэ хуулийн 7.1.1, 7.1.3-т заасан асуудлаар лавлагаа, мэдээллийг нэн даруй, үнэ төлбөргүй гаргаж өгөх үүрэгтэй.

## **8 дугаар зүйл.Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг**

8.1.Үйлчлүүлэгч нь дараах эрх эдэлнэ:

8.1.1.хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах;

8.1.2.улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийн талаар Төвд, өмгөөллийн үйлчилгээний талаар Хуульчдын холбоонд, Төвийн шийдвэр, үйл ажиллагааны талаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус гомдол гаргаж, шийдвэрлүүлэх.



8.2.Үйлчлүүлэгч нь төлбөрийн чадваргүй болохоо үнэн зөв тодорхойлох үүрэгтэй.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ЯЛЛАГДАГЧИД  
ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО**

**9 дүгээр зүйл.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн  
захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

9.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль зүйн туслалцааны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.Төвийг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавих;

9.1.2.төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, боловсронгуй болгох санал боловсруулах;

9.1.3.төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

9.1.4.хууль зүйн туслалцааны хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлтийг хангуулах;

9.1.5.хуульд заасан бусад чиг үүрэг.

**10 дугаар зүйл.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн  
газрын гишүүний бүрэн эрх**

10.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн туслалцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.Төвийн ажлын албаны бүтэц, орон тоог санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтоох;

10.1.2.Төвийн захирлыг томилох, чөлөөлөх, халах;

10.1.3.Төвийн саналыг үндэслэн салбарын байршил, бүтэц, тоо, тухайн салбарт ажиллах улсын өмгөөлөгчийн орон тоог тогтоох, салбарыг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран шийдвэрлэх;



10.1.4.үйлчлүүлэгчтэй болон хувийн өмгөөлөгчтэй байгуулах гэрээний загвар, хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэрийн загварыг батлах;

10.1.5.үйлчлүүлэгчид үзүүлэх хууль зүйн туслалцааны чанар, үр нөлөөг тооцоолох, үнэлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг батлах;

10.1.6.Төвийн дүрэм, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад дүрэм, журмыг батлах;

10.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

10.2.Төвийн дүрэмд дараах зүйлийг тусгана:

10.2.1.Төв, түүний ажлын алба, салбарын эрх, үүрэг;

10.2.2.Төвийн захирал, Төвийн салбарыг ахлах улсын өмгөөлөгчийн захиргааны чиг үүрэг;

10.2.3.улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлын зохион байгуулалт;

10.2.4.ажлын байрны нөхцөл, стандарт;

10.2.5.энэ хуульд заасан бусад зүйл.

10.3.Улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх цалин хөлсний жишгийг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

### **11 дүгээр зүйл.Төвийн удирдлага, зохион байгуулалт**

11.1.Төв нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байна.

11.2.Төв нь ажлын алба, салбараас бүрдэнэ.

11.3.Төвийн ажлын алба нь хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

11.4.Төвийн салбар нь энэ хуулийн 5.1-д заасан хууль зүйн туслалцааг үйлчлүүлэгчид үзүүлнэ.

11.5.Төвийн салбарт улсын өмгөөлөгч ажиллана.



11.6.Улсын өмгөөлөгч нь ажил үүргийн болон хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны зарчмаар зохион байгуулагдан ажиллана.

11.7.Төв нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

## **12 дугаар зүйл.Төвийн ажлын алба, түүний чиг үүрэг**

12.1.Төвийн ажлын алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1.тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоо, гэмт хэргийн гаралт, төлбөрийн чадваргүй яллагдагчийн эзлэх хувь, улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал зэргийг харгалзан Төвийн салбарт ажиллах улсын өмгөөлөгчийн орон тоог тогтоох, шинэчлэн тогтоох, Төвийн салбар байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах эсэх асуудлаар санал боловсруулах;

12.1.2.улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

12.1.3.улсын өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

12.1.4.улсын өмгөөлөгчийн хуульчийн үргэлжилсэн сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

12.1.5.Төвийн салбар байгуулагдаагүй нутаг дэвсгэрт төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;

12.1.6.нийслэлээс бусад газарт байрлах Төвийн салбарыг нүүдэллэн ажиллах үед удирдлага, зохион байгуулалтаар хангах;

12.1.7.хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах;

12.1.8.хууль зүйн туслалцааны чанар, үр нөлөөг тооцоолох, үнэлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

12.1.9.өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх.

12.2.Төвийн ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан нь төрийн захиргааны албан хаагч байна.

12.3.Төвийн ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

### **13 дугаар зүйл.Төвийн захирлын чиг үүрэг**

13.1.Төвийн захирал нь энэ хууль болон дүрмээр олгогдсон эрх хэмжээний дотор Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

13.2.Төвийн захирал нь багшлах, эрдэм шинжилгээнийхээс бусад ажил, албан тушаалыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

13.3.Төвийн захирал нь ажлын албаны дарга байна.

13.4.Төвийн захирал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.4.1.Төвийн дүрмийг боловсронгуй болгох санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

13.4.2.Төвийн салбарын үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглэл өгөх;

13.4.3.Төвийн үйл ажиллагааг сайжруулахтай холбогдсон шаардлагатай арга хэмжээний талаарх саналаа хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

13.4.4.улсын өмгөөлөгчийн цалин хөлсний талаар санал боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах;

13.4.5.хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой гэрээ байгуулах шийдвэр гаргах;

13.4.6.Төв, түүний салбарын үйл ажиллагааны тайлан, мэдээг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, хуулийн дагуу мэдээлэх, нийтэд ил тод хүргэх;

13.4.7.хууль зүйн туслалцааны статистик мэдээг гарган түүнд дүн шинжилгээ хийх;

13.4.8.улсын өмгөөлөгч, Төвийн ажлын албаны ажилтнуудыг томилох, чөлөөлөх, халах;



13.4.9.Төвийн салбарыг ахлах улсын өмгөөлөгчийг ажлын туршлага, мэдлэг, ур чадварыг нь харгалзан томилох, чөлөөлөх, халах;

13.4.10.хувийн өмгөөлөгчийн зардал, тайлангийн загварыг батлах;

13.4.11.улсын өмгөөлөгчийн энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэлээр хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан шийдвэрийг хянах, энэ талаарх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

13.4.12.улсын өмгөөлөгчийн тухайн нутаг дэвсгэртээ нүүдэллэн ажиллах хуваарь, удирдамжийг Төвийн салбарын саналыг харгалзан батлах;

13.4.13.хуульд заасан бусад бүрэн эрх.

#### **14 дүгээр зүйл.Хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг тайлагнах хэлбэр**

14.1.Төв нь санхүүгийн болон үйл ажиллагааны улирал, хагас, бүтэн жилийн тайланг батлагдсан маягтын дагуу, тогтоосон хугацаанд гаргаж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох байгууллагад хүргүүлнэ.

#### **15 дугаар зүйл.Хориглох зүйл**

15.1.Төвийн захирал болон салбарыг ахлах улсын өмгөөлөгч нь дотоод зохион байгуулалтын шинжтэй үйл ажиллагаанаас бусад асуудлаар улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧ, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ, БАТАЛГАА, ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **16 дугаар зүйл.Улсын өмгөөлөгч, түүнийг сонгон шалгаруулах**

16.1.Улсын өмгөөлөгч гэж энэ хуулийн 3.1.4-т заасан хуульчийг хэлнэ.

16.2.Улсын өмгөөлөгч нь Төвийн салбарт ажиллах хуульч байх бөгөөд төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.



16.3.Төвийн ажлын алба нь улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулна.

**17 дугаар зүйл. Улсын өмгөөлөгчийн чиг үүрэг,  
үйл ажиллагаанд хориглох зүйл**

17.1. Улсын өмгөөлөгч нь дараах чиг үүрэгтэй:

17.1.1. хууль зүйн туслалцааг үйлчлүүлэгчид үнэ төлбөргүй үзүүлэх;

17.1.2. үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн, тууштай хамгаалах;

17.1.3. энэ хуулийн 7.4-т заасан өргөдлийг хүлээн авч, холбогдох маягт, бүртгэлийг хөтлөх;

17.1.4. хуульд заасан бусад чиг үүрэг.

17.2. Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаанд дараах үйлдлийг хориглоно:

17.2.1. энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хууль зүйн туслалцаа үзүүлэх;

17.2.2. энэ хуульд зааснаас өөр хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэх;

17.2.3. багшлах, эрдэм шинжилгээний болон Хуульчдын холбоонд хамаарахаас бусад ажил, албан тушаалыг хавсран эрхлэх;

17.2.4. энэ хуулийн 7.7-д заасан мэдээллийг өөр зорилгоор ашиглах.

17.3. Улсын өмгөөлөгч нь мэргэжлийн үйл ажиллагаагаа Хуульчийн мэргэжлийн дүрэмд нийцүүлэн явуулна.

**18 дугаар зүйл. Улсын өмгөөлөгчийн ажиллах  
нөхцөл, баталгаа**

18.1. Улсын өмгөөлөгч нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан өмгөөллийн үйлчилгээний баталгаанаас гадна дараах баталгаагаар хангагдана:



18.1.1.хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдах нөхцөлөөр хангагдах;

18.1.2.өмгөөлөгчийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангагдах;

18.1.3.хуульд заасан үндэслэл журмын дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсны төлөө хариуцлага хүлээхгүй байх.

18.2.Улсын өмгөөлөгч нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.1.1-д заасны дагуу туслахтай байж болно.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ХУВИЙН ӨМГӨӨЛӨГЧИЙГ ОРОЛЦУУЛАХ**

#### **19 дүгээр зүйл.Хувийн өмгөөлөгчийг оролцуулах нөхцөл**

19.1.Хувийн өмгөөлөгчийг дараах нөхцөлд төлбөрийн чадваргүй яллагдагчийн өмгөөлөгчөөр ажиллуулна:

19.1.1.улсын өмгөөлөгч нь үйлчлүүлэгчтэй ашиг сонирхлын зөрчилтэй;

19.1.2.нэг хэрэгт харилцан эсрэг сонирхолтой хоёр ба түүнээс дээш үйлчлүүлэгч хууль зүйн туслалцаа авах өргөдөл гаргасан;

19.1.3.үйлчлүүлэгч нь холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу улсын өмгөөлөгчөөс татгалзсан;

19.1.4.тухайн нутаг дэвсгэрт Төвийн салбар байхгүй.

19.2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45.1.11-д заасан Хуульчдын холбооны чиг үүргийг хувийн өмгөөлөгчийн төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй уялдуулан зохицуулна.

19.3.Төв нь хувийн өмгөөлөгчийг ажиллуулахдаа төлбөрийн чадваргүй яллагдагчид өмгөөллийн үйлчилгээг сайн дурын үндсэн дээр үзүүлэх хувийн өмгөөлөгчдөөс, байхгүй тохиолдолд үйлчлүүлэгч нь тухайн нутаг дэвсгэрт өмгөөллийн үйлчилгээ явуулж байгаа өмгөөлөгчид хүсэлт гаргаснаар оролцуулна.

19.4.Төвийн салбар нь хувийн өмгөөлөгчийг ажиллуулах нөхцөл бий болсон тохиолдолд хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулна.



19.5.Хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн үйлчилгээний ажлын хөлсний жишгийг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно.

19.6.Энэ хуулийн 19.5-д заасан жишгийг тогтооходоо Төвд ажиллаж байгаа улсын өмгөөлөгчийн цалин хөлсний жишгээр тогтооно.

## **20 дугаар зүйл.Төлбөрийг гүйцэтгэх, түүний санхүүжилтийн хэлбэр**

20.1.Энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу гэрээгээр өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн хувийн өмгөөлөгч нь холбогдох стандартын дагуу хэргийн материалыг бүрдүүлж, өмгөөллийн үйлчилгээний тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд тухайн Төвийн салбарт ирүүлнэ.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан материалтай тухайн Төвийн салбарыг ахлах улсын өмгөөлөгч танилцаж, гэрээний гүйцэтгэлийг дүгнэх бөгөөд энэ нь төлбөр гүйцэтгэх үндэслэл болно.

20.3.Хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн ажлын хөлсийг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ САНХҮҮЖИЛТ**

### **21 дүгээр зүйл.Санхүүжилтийн эх үүсвэр**

21.1.Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **22 дугаар зүйл.Хууль сурталчлах үйл ажиллагаанд оролцох**

22.1.Төв, түүний салбар нь төлбөрийн чадваргүй иргэдэд хууль сурталчлах, орон нутгийн хууль сурталчлах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж болно.

### **23 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

23.1.Энэ хуулийн 8.2-т заасныг зөрчсөн иргэнд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



23.2.Энэ хуулийн 16.1, 16.2, 17.2-т заасан шаардлага хангаагүй, хориглосон үйл ажиллагаа явуулсан улсын өмгөөлөгчтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцалж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилтэй холбогдох аливаа үйлдэл, эс үйлдэхүйг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Төв нь Мэргэжлийн хариуцлагын хороонд мэдэгдэнэ.

#### **24 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

24.1.Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

### **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2013 оны 4 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар  
хот

#### **Үндэсний хөтөлбөр батлах тухай**

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ажилтай, орлоготой Монгол хүн" үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбарын болон орон нутгийн дэд зөвлөл, ажлын албыг байгуулан ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж, гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөртэй уялдуулан санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.



4. Үндэсний хөтөлбөрийн явц, үр дүнг нэгтгэн жил бүрийн II улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хөдөлмөрийн сайд Я.Санжмятавт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Я.САНЖМЯТАВ**

Засгийн газрын 2013 оны 154 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

**“АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН”  
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Хөтөлбөр хэрэгжүүлэх үндэслэл,  
шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний<sup>1</sup> 145-д “Ажилтай, орлоготой Монгол хүн” хөтөлбөр хэрэгжүүлж, 150000 байнгын ажлын байр шинээр бий болгох зорилт дэвшүүлсэн.

Энэхүү зорилтын хүрээнд салбар хоорондын уялдааг хангах, иргэдийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг өргөжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх суурь хөтөлбөр болох “Ажилтай, орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг боловсруулсан болно.

Ажилгүйдэл нь улс оронд эдийн засгийн бөгөөд нийгмийн сөрөг үр дагаврыг бий болгодог. Тодруулбал, хэвийн ажилгүйдлийн түвшин 1 хувиар өсөхөд ДНБ-ийг 2.5 хувиар нэмэгдүүлэх боломжийг алддаг<sup>2</sup> гэж онолын хувьд үздэг.

Манай улсын хувьд хүн ам зүйн онцлог болох “Хүн ам зүйн цонх” үе тохиож байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын өсөлт болон ажиллах хүч, ажиллагчдын бүтцэд өөрчлөлт гарч, хөдөлмөрийн зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлж байна. Тухайлбал, хөдөлмөрийн насны хүн амын өсөлт 2009-2012 оны хооронд 3.5 хувьтай байгаа нь нийт хүн амын өсөлттэй харьцуулахад 2 дахин их байна. Түүнчлэн ажиллах хүч 9.4 хувь, ажиллагчид 12.1 хувиар тус тус өсчээ.

<sup>1</sup>Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоол

<sup>2</sup>Артур Оукены хууль



Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт өндөр байгаа хэдий ч ажлын байрны тогтвортой өсөлтийг бий болгож чадахгүй байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2002-2008 онд дунджаар 6.5 хувиар, 2011-2012 онд 17.3 хувиар өссөн хэдий ч ажилгүйдлийн түвшин дорвитой буурахгүй хэвээр байна<sup>3</sup>.

Ажиллах хүчний түүвэр судалгааны дүнгээр 2012 оны III улиралд 75.3 мянган хүн ажил эрхлээгүй байгаагийн 38.0 мянга буюу 50.4 хувь нь эрэгтэйчүүд, 37.3 мянга буюу 49.5 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ажилгүйдлийн түвшин 2012 оны I улиралд 10.3, II улиралд 8.4, III улиралд 6.3 хувьтай байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлэн, ажил идэвхтэй хайж байгаа иргэдийн тоо 2012 оны 9 дүгээр сарын эцсээр 44.1 мянга, оны эцэст 35.7 мянга байна.

2012 оны эцсээр нийт бүртгэлтэй байгаа ажилгүй иргэдийн 30.0 хувь нь дээд, 12.0 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд, 54.7 хувь нь бүрэн болон суурь боловсролтой, 5.3 хувь нь бага болон боловсролгүй иргэд байна.

Хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжийг хөгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, ажилгүйдэл, орлогын хүрэлцээгүй байдлыг бууруулах, ажилгүй иргэдийг ажлын байраар ханган эдийн засаг, орлого бий болгох үйл ажиллагаанд оролцуулах, ажилгүйдлийн нийгэмд үзүүлж буй сөрөг үр дагаврыг бууруулж, шинэчлэлийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хангахад энэхүү үндэсний хөтөлбөр чиглэгдэнэ.

Энэ хөтөлбөр нь хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн бодлого, үйл ажиллагааг үйлдвэржилт, бүтээн байгуулалттай уялдуулан хэрэгжүүлж, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн хөгжүүлэх, ажиллах хүчний оролцоог боломжит түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэх, салбар дундын уялдаа, холбоог сайжруулах зэрэг нийтлэг зарчим, нэгдсэн бодлогын суурь болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, баримтлах зарчим

2.1. Төр-хувийн хэвшлийн түншлэл, өөртөө ажлын байр бий болгох иргэдийн санаачлагад тулгуурласан хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг бусад салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх замаар 150000-аас доошгүй

<sup>3</sup>Монгол Улсад ажлын байрыг дэмжигч олон талыг хамарсан өсөлтийг бий болгоход тулгарч буй бэрхшээлүүд, ОУХБ, Хөдөлмөр эрхлэлтийн илтгэл, 2011

байнгын шинэ ажлын байр бий болгож, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийг 2013-2016 онд хэрэгжүүлнэ.

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

2.3.1. Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай 22 дугаар конвенцид нийцүүлэн хүн бүрт хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх суурь зарчмыг мөрдлөг болгох;

2.3.2. олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан Хөдөлмөрийн хүрээний суурь зарчмууд, үндсэн эрхүүдийн тухай Тунхаглал, Зохистой хөдөлмөрийн үзэл баримтлалыг удирдлага болгон ажилтнуудын эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхийг хэрэгжүүлэх, хүүхдийн болон албадан хөдөлмөр, хөдөлмөрийн харилцаан дахь аливаа ялгаварлал, гадуурхлыг устгах зорилтыг нэн тэргүүнд хангах;

2.3.3. ажлын байранд хүн бүр аливаа ялгаварлалгүй, адил, тэгш хүрэх боломжийг бүрдүүлэх замаар хөдөлмөрийн харилцааны тэгш бус байдлыг багасгах;

2.3.4. эдийн засгийн салбарууд болон төрийн бүх шатны байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, хөдөлмөр, нийгмийн зөвшилцөл, төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан идэвхтэй оролцоог хангах;

2.3.5. Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний стратеги, хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй нягт уялдуулах;

2.3.6. ажлын байр бий болгоход эдийн засаг, санхүүгийн нөөцийг уялдуулан зарцуулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх, үйлдвэржилтийн бодлогод суурилах.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, ажлын байрыг тогтвортой хадгалахад дэмжлэг үзүүлнэ:

3.1.1. барилга, зам, тээвэр, аялал жуулчлал, байгаль орчин, уул уурхай, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, худалдаа, үйлчилгээ, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн



захиргааны төв байгууллагатай хамтран төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах;

3.1.2. эдийн засаг, санхүүгийн хямрал болон бусад давагдашгүй хүчин зүйлийн үед ажлын байрыг тогтвортой хадгалсан ажил олгогчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх орчинг бий болгох;

3.1.3. зохистой хөдөлмөрийг дэмжих замаар бүтээмжтэй, аюулгүй ажлын байрыг бий болгон, тогтвортой хадгалж байгаа ажил олгогчийг зээлийн бодлогоор дэмжих, урамшуулах тогтолцоо бий болгох;

3.1.4. үйлдвэрлэлийн кластерт ажлын байр бий болгосон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.5. Монголд үйлдвэрлэдэг болон үйлдвэрлэх боломжтой бараа, бүтээгдэхүүний дотоодын зах зээлийг хамгаалах, гааль, татварын бодлогоор дэмжих;

3.1.6. нэмүү өртөг бий болгодог боловсруулах аж үйлдвэрт ажиллагчдыг санхүү, эдийн засгийн бодлогоор дэмжих урамшууллын тогтолцоог бий болгох;

3.1.7. хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжүүдэд тохирох хөдөлмөрийн харилцааны болон хөдөлмөр зохицуулалт, татвар, даатгал, шимтгэлийн бодлого, дэмжлэгийг бий болгох;

3.1.8. үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөжүүлэх замаар ажил олоход хүндрэлтэй иргэнийг байнгын ажлын шинэ байраар хангасан, мөн ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн ажлын байр тогтвортой хадгалсан тохиолдолд ажил олгогчид цалингийн дэмжлэг, урамшуулал олгох, сургалтын зардлыг нөхөн төлөх хэлбэрээр дэмжлэг үзүүлэх.

3.2. Жижиг, дунд үйлдвэр болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэд, малчдыг зээл, санхүүгийн үйлчилгээгээр дэмжинэ:

3.2.1. хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох зорилго бүхий жижиг зээлийн хугацааг нэмэгдүүлж, зээлийн хүүг нөхөн олгох, зээлийн батлан даалтын сан байгуулах;

3.2.2. жижиг, дунд үйлдвэр болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэд, малчдад олгох зээлийн эх үүсвэрийг жил бүр нэмэгдүүлж, хүн амын төвлөрлийг сааруулах бодлогын арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэх;



3.2.3. жижиг, дунд үйлдвэр, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөрлөл, бүлгийн зохион байгуулалтыг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь худалдан борлуулах механизмыг боловсронгуй болгох;

3.2.4. ахуй үйлчилгээний цогцолбор төвийг бүх суманд байгуулах замаар ажлын байр нэмэгдүүлэх, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах;

3.2.5. жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, бизнес инкубаторын төвийг бүх аймагт байгуулж, үйл ажиллагааг өргөжүүлэх;

3.2.6. хөдөө аж ахуйн гаралтай үйлдвэрлэл, түүхий эд бэлтгэн нийлүүлэх зохион байгуулалтыг хөгжүүлэх нөхөрлөл, хоршоо байгуулахыг дэмжих;

3.2.7. жижиг, дунд үйлдвэр эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах, технологи нэвтрүүлэхэд зориулж төрөөс санхүү, эдийн засгийн болон татвар, гаалийн дэмжлэг үзүүлэх.

3.3. Хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжил, ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн судалгааг үндэслэн ажил олгогчийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ:

3.3.1. хөдөлмөрийн судалгааны институтын чадавхийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчин, ажлын байрыг салбар, бүс болон бусад шаардлагатай чиглэлээр тодорхойлох;

3.3.2. хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчдын хэрэгцээг үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад элсэгчдийг бүртгэх, төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлэх;

3.3.3. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдын сургалтын тэтгэлгийг нэмэгдүүлэх замаар суралцах сонирхлыг нь дэмжиж ажиллах;

3.3.4. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гаргаж, ажил эрхлэлтийн түвшинг нийтэд зарлах;



3.3.5. ерөнхий боловсролын сургуульд суралцагчдад хөдөлмөрийн харилцааны мэдлэг, ёс зүйг төлөвшүүлэн, мэргэжлийн чиг баримжаа олгох замаар хөдөлмөрт бэлтгэх;

3.3.6. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын хичээл-дадлагын баазыг өргөтгөх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, суралцагчдын сурах орчинг сайжруулан чадамжид суурилсан сургалтын тогтолцоог төлөвшүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

3.3.7. ажилгүйдлийн даатгалын сангаас олгох сургалтын зардлыг нэмэгдүүлэх замаар ажилгүй иргэд мэргэжлийн ур чадвараа сайжруулах, шинээр мэргэжил эзэмших бололцоог хангах;

3.3.8. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үндэсний хэмжээний томоохон үйлдвэрлэл бүхий аж ахуйн нэгжийн дэргэд байгуулах, төрөлжүүлэх замаар мэргэжилтэй ажилтныг бэлтгэн нийлүүлэх.

3.4. Өндөр технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардагдах мэргэжилтэй ажилтныг урт болон богино хугацаагаар сургаж, мэргэшүүлэх замаар эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбарын хэрэгцээг үндэсний ажиллах хүчээр хангана:

3.4.1. өндөр технологи, тоног төхөөрөмжид суурилсан мэдлэг олгоход чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.4.2. хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үндэслэн орчин үеийн дэвшилтэт техник, технологи дээр ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр төрийн зардлаар урт хугацаагаар бэлтгэж, ажлын байраар хангах;

3.4.3. эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбаруудад шаардагдах мэргэжилтэй ажилтныг ажлын байран дээр болон үйлдвэрлэл дээр тодорхой гэрээний дагуу богино хугацаанд сургах, улмаар ажлын байраар хангах арга хэмжээг зохион байгуулах;

3.4.4. орчин үеийн дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж ашиглаж байгаа томоохон аж ахуйн нэгжүүдэд ажилтныг дадлагажуулан бэлтгэх.

3.5. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулахад хувийн хэвшлийн оролцоог



нэмэгдүүлж, нийгмийн түншлэлийн байгууллагуудын идэвх, санаачлагыг дэмжинэ:

3.5.1. хөдөлмөрийн суурь зарчим, хөдөлмөрлөх эрхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, хөдөлмөрийн харилцаанд шударга, тэгш байдлыг хангахад төр-хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжих;

3.5.2. хөдөлмөр эрхлэлтийн удирдлага, бодлого зохицуулалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, төр-хувийн хэвшил, нийгмийн түншлэгч байгууллагуудын санал санаачлага, хамтын ажиллагааг дэмжиж, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3.5.3. төр-хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, төрийн зарим үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хүрээг өргөжүүлэн үр дүнг сайжруулах;

3.5.4. хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, хөдөлмөрийн харилцааны хэв шинжүүдийг төлөвшүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.5.5. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдлэгийг иргэд, ажилтанд олгох, энэ чиглэлийн сургалтыг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын хичээлийн хөтөлбөрт тусгах;

3.5.6. хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт болон салбар, орон нутгийн түншлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар нийгмийн түншлэгчид, бусад холбогдох талуудтай хамтран ажиллаж, тэдгээрийн оролцоог хангах;

3.5.7. гадаадын хөрөнгө оруулалттай, аж ахуйн нэгж, байгууллагуудын нийгмийн хариуцлагын тогтолцоог сайжруулах;

3.5.8. ажил, хөдөлмөр эрхэлж байгаа боловч орлого багатай, бүрэн бус хөдөлмөр эрхэлж байгаа иргэдэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд төр-хувийн хэвшлийн оролцоог хангах;

3.5.9. эдийн засгийн үйл ажиллагааны албан бус салбарт ажиллаж байгаа иргэдийг албан салбарт шилжүүлэх эдийн засгийн хөшүүрэг бий болгох, төрөөс дэмжлэг үзүүлэх.



3.6. Хүн амын хэт төвлөрлийг сааруулахад хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг чиглүүлэн, орон нутагт ажлын байр бий болгох санал, санаачлагыг дэмжиж, урамшуулна.

3.6.1. орон нутагт боловсруулах үйлдвэрлэл байгуулж, байнгын ажлын байр бий болгож байгаа ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих татвар, зээл зэрэг эдийн засгийн бусад хөшүүргийг бий болгох;

3.6.2. орон нутгийн онцлог, давуу тал, нөөц бололцоонд тулгуурлан ажлын байр бий болгох “Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” дэд хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

3.6.3. бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг дагасан хүн амын шилжих хөдөлгөөнд бэлтгэн нийгэм, эдийн засгийн цогц бодлогыг төлөвлөж, төрийн үйлчилгээний хамрах хүрээг өргөжүүлэх;

3.6.4. орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн орон нутагт дэд бүтэц хөгжүүлэх, байгалийн нөхөн сэргээлт хийх, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үүрэг оролцоог нэмэгдүүлэх;

3.6.5. нийслэлээс орон нутагт шилжин суурьших иргэдэд ажлын байр бий болгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор Дархан, Эрдэнэт зэрэг төвлөрсөн газруудад олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх.

3.7. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгож, иргэн оршин суугаа газраасаа харьяалал үл харгалзан хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлнэ:

3.7.1. хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны талаархи үндсэн мэдээлэл, динамикийг агуулсан бүртгэл, мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх;

3.7.2. хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг, дунд үйлдвэрлэлийн асуудлаар бүртгэл, статистикийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх;

3.7.3. төвлөрсөн суурин, сум, хороонд мэдээллийн сүлжээ, программ хангамж, цахим хайлтын биет системийг нэвтрүүлэх замаар



хөдөлмөр эрхлэлт, ажилд зуучлалын үйлчилгээг оршин суугаа харьяалал харгалзахгүй үзүүлэх;

3.7.4. хөдөлмөрийн хувийн биржийг хөдөлмөр эрхлэлтийн онлайн мэдээллийн системд холбож, нэгдмэл орчинд ажил зуучлалын үйлчилгээг хүргэх;

3.7.5. хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн тогтолцоог бусад салбарын мэдээллийн сантай уялдуулан, мэдээлэл солилцох, хянах, түгээх боломж бүрдүүлэх.

3.8. Цалин хөлсний бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох замаар ажиллагчдын бүтээмж, ур чадварыг урамшуулан хөдөлмөрлөх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ:

3.8.1. цалин хөлсний талаар баримтлах үндэсний бодлогыг батлуулж, хэрэгжүүлэх;

3.8.2. үндэсний, бүс нутгийн, салбарын болон аж ахуйн нэгжийн түвшинд бүтээмжид суурилсан цалин хөлсний зохицуулалтыг бүрдүүлэх;

3.8.3. үндэсний хэмжээнд хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөн өрнүүлж, цалин хөлс, хөдөлмөрийн бүтээмжийн талаархи нийгмийн ойлголтыг нэмэгдүүлж цалин хөлс болон хөдөлмөрийн бүтээмжийн уялдаа холбоог хангах аргачлал, арга зүйг боловсронгуй болгох;

3.8.4. ажиллагчдын үндсэн цалингийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан тухай бүр индексжүүлэн нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

3.8.5. хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үндэсний болон бүс нутаг, салбарын түвшинд тарифын хэлэлцээрээр, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хамтын гэрээ, хэлэлцээрээр ажил олгогч, ажилтны төлөөлөл хамтран тогтоож мөрдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх.

3.9. Албан бус хэвшилд ажиллагчид болон хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн ажил, орлоготой болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор дор дурдсан хөдөлмөр эрхлэлтийн тусгайлсан хөтөлбөр, төслийг хэрэгжүүлнэ:

3.9.1. залуучуудын хөдөлмөр эрхлэлт;



3.9.2. гадаадад ажиллаж, амьдарч байгаад буцаж ирсэн иргэний хөдөлмөр эрхлэлт;

3.9.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт;

3.9.4. ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт;

3.9.5. 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлт;

3.9.6. тэтгэврийн насанд хүрээгүй боловч хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох эрх үүсч ажилгүй болсон иргэдийн хөдөлмөр эрхлэлт;

3.9.7. томоохон бүтээн байгуулалт, үйлдвэржилтийг дагасан хот, сууринд болон алслагдсан цэргийн ангид суурьшсан өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт;

3.9.8. хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлт;

3.9.9. сумын төв, алслагдсан суурингийн залуучуудын хөдөлмөр эрхлэлт;

3.9.10. хөнгөн ял эдэлж байгаа иргэн болон хугацаат цэргийн албан хаагчийг хөдөлмөрт бэлтгэх.

3.10. Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан боловсронгуй болгоно:

3.10.1. эдийн засгийн салбарт хэрэгцээтэй байгаа ажиллах хүчийг гадаадаас авахад тавигдах мэргэжил, боловсрол, эрүүл мэндийн шалгуурыг боловсронгуй болгох;

3.10.2. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаадын иргэний ажлын байрны төлбөрийг салбарын онцлог, дотоодын ажиллах хүчний нийлүүлэлттэй уялдуулан уян хатан тогтоож, улмаар үндэсний ажиллах хүчийг тогтоосон квотын дагуу сургаж, дадлагажуулахад дэмжлэг үзүүлэх;

3.10.3. ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдсөн болон ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь квот, заасан хугацаа зөрчсөн тохиолдолд ажлын байрны төлбөрийг тогтоосон хэмжээнээс нэмэгдүүлэн нөхөн төлөх зэргээр хариуцлагын тогтолцоог чангатгах;



3.10.4. гадаадад ажиллах хүч зуучлах үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгож, зуучлах үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх, Монгол Улсын иргэд гадаадад хөдөлмөрлөхтэй холбоотой эрхийг хангахад дэмжлэг үзүүлэх;

3.10.5. гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа монгол иргэдийг мэргэшүүлэх, тухайн улсаас олгосон мэргэжил, ур чадварын гэрчилгээг хүлээн зөвшөөрөх тогтолцоог бий болгох;

3.10.6. гадаадад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийн эрх ашиг, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамгаалах, эрх зүйн зөвлөгөө өгөх, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах зэрэг ажлыг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.10.7. гадаадад ажиллаж, амьдарч байгаад буцаж ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах, өндөр хөгжилтэй орнуудын дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

3.11. Нийтийн эрх ашгийг хангах, ногоон хөгжлийн үйл ажиллагаанд ажилгүй иргэн, хөдөлмөрлөх боломжтой хүн амыг хамруулан орлогоор дэмжинэ:

3.11.1. “Эзэнтэй Монгол” хөтөлбөрийн хүрээнд байгалийн аюулт үзэгдэл, доройтол, гамшгийн үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг ажил эрхлээгүй, ажил эрхлэх боломжтой иргэдийг оролцуулан зохион байгуулж, орлогоор дэмжих;

3.11.2. орон нутагт хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрт болон ялангуяа зам, барилга байгууламж барихад дагалдах үйл ажиллагаанд нутгийн ажилгүй иргэдийг ажиллуулдаг механизмыг бий болгох;

3.11.3. “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл”-ийг дэмжиж, ногоон ажлын байр бий болгох.

Дөрөв. Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

4.1.1. 150000<sup>4</sup>-гаас доошгүй байнгын, шинэ ажлын байр бий болсон байна;

<sup>4</sup>“Байнгын, тогтвортой ажлын байр” гэдгийг ҮСХ-ны дарга, НХХ-ийн сайдын 2009 оны 01-68/94 тоот тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалд заасан “Байнгын ажилтан”-г ажиллуулж байгаа ажлын байр гэж ойлгоно.



4.1.2. 2016 онд ажиллах хүчний оролцооны түвшин улсад дунджаар 67 хувьд хүрч, ажилгүйдлийн түвшин 5.0 хувиас ихгүй болсон байна;

4.1.3. эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн хөтөлбөр, арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлсэн байна;

4.1.4. хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх болон үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна;

4.1.5. хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийг зохицуулсан хууль тогтоомж боловсронгуй болж, хөдөлмөрлөх таатай орчинг бүрдүүлэхэд ахиц гарсан байна;

4.1.6. хөдөлмөрийн зах зээлд эрэлт, нийлүүлэлт тэнцвэржиж, мэргэжилтэй ажилтны нийлүүлэлт нэмэгдсэн байна;

4.1.7. хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээний хамрах хүрээ өргөжсөн, үр дүн дээшилсэн байна;

4.1.8. гадаадад хөдөлмөр эрхлүүлэх, гадаадаас ажиллах хүч авах бодлого, эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт орсон байна;

4.1.9. хөдөлмөрийн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого боловсронгуй болж, иргэдийн хөдөлмөрлөх хүсэл сонирхол нэмэгдэн цалин, орлого нь нэмэгдсэн байна;

4.1.10. хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмжид эерэг өөрчлөлт гарч, эдийн засгийн өсөлт нь ажиллагчдын тооны өсөлт, бүтээмжийн өсөлтийг хангахад зохих хувь нэмэр оруулсан байна.

4.2. Хөтөлбөрийг дараахь үр дүнгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтээр хэмжинэ:

4.2.1. бий болсон байнгын ажлын байрны тоо;

4.2.2. ажиллах хүчний оролцооны түвшин;

4.2.3. ажилгүйдлийн түвшин;

4.2.4. хөтөлбөрийн хүрээнд бий болгосон дэмжлэг, урамшуулал, хөнгөлөлт, хөшүүрэг болон арга хэмжээний тоо, хэлбэр, хэмжээ;



4.2.5. хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэний тоо, төрөл, байршил тус бүрээр;

4.2.6. хөдөлмөрийн зах зээлийн нарийвчилсан судалгаа, тэдгээрийн үр дүнг хөтөлбөр, төсөлд тусгасан байдал;

4.2.7. хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ хүртсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;

4.2.8. шинээр бий болсон үйлдвэр, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийн тоо;

4.2.9. шинээр боловсруулсан хууль тогтоомж, эрх зүйн актын тоо;

4.2.10. хэрэгжүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслийн тоо.

#### Тав. Удирдлага, зохион байгуулалт

5.1. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах үүрэг бүхий орон тооны бус Үндэсний зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) ажиллах бөгөөд Зөвлөлийг Хөдөлмөрийн сайд удирдана. Сангийн дэд сайд Зөвлөлийн орлогч дарга байна.

5.2. Салбар болон орон нутгийн дэд зөвлөлүүд байх бөгөөд салбарын дэд зөвлөлийг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн дэд зөвлөлийг аймаг, нийслэлийн Засаг дарга нар удирдана.

5.3. Зөвлөлийн ажлын албаны үүргийг Хөдөлмөрийн яам, орон нутгийн дэд зөвлөлийн ажлын албаны үүргийг тухайн аймаг, нийслэлийн Хөдөлмөрийн хэлтэс гүйцэтгэнэ.

5.4. Салбарын дэд зөвлөлийн ажлын алба нь тухайн салбарын яам байх бөгөөд аймаг, нийслэлд үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгж нь тухайн салбарын орон нутгийн байгууллага байна.

#### Зургаа. Хөтөлбөрийн хамрах хүрээ, санхүүжилт

6.1. Хөтөлбөрт дараахь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулна:



6.1.1. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага;

6.1.2. ажлын байр бий болгосон ажил олгогч;

6.1.3. ажил хайгч иргэн;

6.1.4. ажилгүй иргэн;

6.1.5. ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн;

6.1.6. ажил олоход хүндрэлтэй иргэн;

6.1.7. малчин;

6.1.8. хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн;

6.1.9. гадаад улсад амьдарч, хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн;

6.1.10. Үндэсний хөтөлбөрт заасан бусад иргэн, байгууллага.

6.2. Энэ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүдийн хамрах хүрээг хөтөлбөр тус бүрт хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлно.

6.3. Хөтөлбөрийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

6.3.1. улсын төсөв;

6.3.2. орон нутгийн төсөв;

6.3.3. хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилго бүхий Засгийн газрын тусгай сангуудаас хуваарилагдсан хөрөнгө (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Мэргэжлийн боловсрол, сургалтын сан, Сум хөгжүүлэх сан болон холбогдох бусад сан);

6.3.4. олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

6.3.5. хандив болон бусад.

6.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусган батлуулж, санхүүжүүлнэ.



6.5. Хөтөлбөрийн санхүүжилтийг хөтөлбөрт заасан бодлого, арга хэмжээний хүрээнд тухайн жилийн төсөвт тусгагдсан хөрөнгийн дүнд багтаан батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, тайлагнана.

#### Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага жил бүр хяналт-шинжилгээ хийнэ. Хяналт-шинжилгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд үндэслэн үнэлгээг хийлгэх бөгөөд эцсийн үр дүнгийн судалгаа, шинжилгээг хөндлөнгийн байгууллагын оролцоотойгоор, шаардлагатай бол мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

7.3. Салбарын болон орон нутгийн дэд зөвлөлүүд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ бүрээр улирал бүр гаргаж, дүнг тухайн салбар болон дэд зөвлөлөөр хэлэлцэж, дараа улирлын эхний сарын 10-ны дотор Хөдөлмөрийн яаманд, Хөдөлмөрийн яам хэрэгжилтийн үр дүнгийн дэлгэрэнгүй тайланг хагас жилээр гаргаж, тухайн оны 7 дугаар сарын 20, дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний зөвлөлд тус тус хүргүүлж, тайлагнана.

7.4. Хөдөлмөрийн яам нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн Зөвлөлөөр хэлэлцүүлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнтэй уялдуулан дэд зөвлөлийг урамшуулах, хариуцлага тооцох болон бусад зохион байгуулалтын арга хэмжээний талаар Хөдөлмөрийн яам санал боловсруулж, Зөвлөлд танилцуулж болно.

7.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаархи мэдээ, тайланг холбогдох байгууллагууд цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

Засгийн газрын 2013 оны 154 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

“АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр
Зорилт 1. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, ажлын байрыг тогтвортой хадгалахад дэмжлэг үзүүлнэ.					
1.	Барилга, зам, тээвэр, аялал жуулчлал, байгаль орчин, уул уурхай, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, худалдаа, үйлчилгээ, ахуй үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангана.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Уул, уурхайн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Эрчим хүчний яам	Улсын төсөв
2.	Эдийн засаг, санхүүгийн хямрал болон бусад давагдашгүй хүчин зүйлийн үед ажлын байрыг тогтвортой хадгалсан ажил олгогчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх орчинг бий болгоно.	2013-2016	Сангийн яам, Хөдөлмөрийн яам	Эдийн засгийн хөгжлийн яам	Улсын төсөв
3.	Зохистой хөдөлмөрийг дэмжих замаар бүтээмжтэй, аюулгүй ажлын байрыг бий болгон, тогтвортой хадгалж байгаа ажил олгогчийг зээлийн бодлогоор дэмжиж, урамшуулах тогтолцоо бий болгоно.	2013-2014	Сангийн яам, Хөдөлмөрийн яам	Эдийн засгийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Улсын төсөв
4.	Үйлдвэрлэлийн кластерт ажлын байр бий болгосон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Сангийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
5.	Монголд үйлдвэрлэдэг болон үйлдвэрлэх боломжтой бараа, бүтээгдэхүүний дотоодын зах зээлийг хамгаалан гааль, татварын бодлогоор дэмжинэ.	2013-2016	Сангийн яам, Хөдөлмөрийн яам	Эдийн засгийн хөгжлийн яам	Улсын төсөв
6.	Нэмүү өртөг бий болгодог боловсруулах аж үйлдвэрт ажиллагчдыг санхүү, эдийн засгийн бодлогоор дэмжин урамшууллын тогтолцоог бий болгоно.	2013-2016	Сангийн яам, Хөдөлмөрийн яам	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	Улсын төсөв

7.	Хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжүүдэд тохирох хөдөлмөрийн харилцааны болон хөдөлмөр зохицуулалт, татвар, даатгал, шимтгэлийн бодлого, дэмжлэгийг бий болгоно. Үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх замаар ажил олоход хүндрэлтэй иргэнийг байнгын ажлын шинэ байраар хангасан, мөн ажиллүүдэлд өртөж болзошгүй иргэдийн ажлын байрыг тогтвортой хадгалсан тохиолдолд ажил олгогчид цалингийн дэмжлэг, урамшуулал олгох, сургалтын зардлыг нөхөн төлөх хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	Сангийн яам, Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв
8.		2013-2016	Хөдөлмөрийн яам	-	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
Зорилт 2. Жижиг, дунд үйлдвэр болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэд, малчдыг зээл, санхүүгийн үйлчилгээгээр дэмжинэ.					
1.	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох зорилто бүхий жижиг зээлийн хугацааг нэмэгдүүлж, зээлийн хүүг нөхөн олгох, зээлийн батлан даалтын сан байгуулна.	2013	Хөдөлмөрийн яам	Сангийн яам	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
2.	Жижиг, дунд үйлдвэр болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэд, малчдад олгох зээлийн эх үүсвэрийг жил бүр нэмэгдүүлж, хүн амын төвлөрлийг сааруулах бодлогын арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлнэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Сангийн яам	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
3.	Жижиг, дунд үйлдвэр, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөрлөл, бүлгийн зохион байгуулалтыг дэмжиж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь худалдан борлуулах механизмыг боловсронгуй болгоно.	2014	Хөдөлмөрийн яам	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
4.	Ахуй үйлчлэлтний цогцолбор төвийг бүх суманд байгуулах замаар ажлын байр нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.	2015	Хөдөлмөрийн яам	-	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
5.	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, бизнес инкубаторын төвийг бүх аймагт байгуулж, үйл ажиллагааг өргөжүүлнэ.	2015	Хөдөлмөрийн яам	-	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
6.	Хөдөө аж ахуйн гаралтай үйлдвэрлэл, түүхий эд бэлтгэн нийлүүлэх зохион байгуулалтыг хөгжүүлэх нөхөрлөл, хоршоо байгуулахыг дэмжинэ.	2013-2016	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	Хөдөлмөрийн яам	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан



7. Жижиг, дунд үйлдвэр эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах, технологи нэвтрүүлэхэд зориулж төрөөс санхүү, эдийн засгийн болон татвар, гаалийн дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	Сангийн яам, Хөдөлмөрийн яам	Эдийн засгийн хөгжлийн яам	Улсын төсөв
Зорилт 3. Хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжил, ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн судалгааг үндэслэн ажил олгогчийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ.				
1. Хөдөлмөрийн судалгааны институтийн чадавхийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчин, ажлын байрыг салбар, бүс болон шаардлагатай бусад чиглэлээр тодорхойлно.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Салбарын яамд	Улсын төсөв
2. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчдын хэрэгцээг үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагод элсэгчдийг бүртгэх, төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	2014	Хөдөлмөрийн яам	-	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагод суралцагчдын сургалтын тэтгэлгийг нэмэгдүүлэх замаар суралцах сонирхлыг нь дэмжиж ажиллана.	2013	Хөдөлмөрийн яам	Сангийн яам	Улсын төсөв
4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гаргаж, ажил эрхлэлтийн түвшинг нийтэд зарлана.	2014	Хөдөлмөрийн яам	-	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
5. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдад хөдөлмөрийн харилцааны мэдлэг, ёс зүйг төлөвшүүлэн, мэргэжлийн чиг баримжаа олгох замаар хөдөлмөрт бэлтгэнэ.	2015	Хөдөлмөрийн яам	Боловсрол, шинжлэх ухааны яам	Улсын төсөв
6. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын хичээл-дадлагын баазыг өргөтгөх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэн, суралцагчдын сурах орчинг сайжруулан чадамжид суурилсан сургалтын тогтолцоог төлөвшүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Сангийн яам	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
7. Ажилгүйдлийн даатгалын сангаас олгох сургалтын зардлыг нэмэгдүүлэх замаар ажилгүи иргэд мэргэжлийн ур чадвараа сайжруулах шинээр мэргэжил эзэмших бололцоог хангана.	2014	Хөдөлмөрийн яам	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Ажилгүйдлийн даатгалын сан
8. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг үндэсний хэмжээний томоохон үйлдвэрлэл бүхий аж ахуйн нэгжийн дэргэд байгуулж, төрөлжүүлэх замаар мэргэжилтэй ажилтныг бэлтгэн нийлүүлнэ.	2014-2016	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв



Зорилт 4. Өндөр технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардагдах мэргэжилтэй ажилтныг урт болон богино хугацаагаар сургаж, мэргэшүүлэх замаар эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбарын хэрэгцээг үндэсний ажиллах хүчээр хангана.

1.	Өндөр технологи, тоног төхөөрөмжид суурилсан мэдлэг олгоход чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2015	Хөдөлмөрийн яам	Зам, тээврийн яам, Уул, уурхайн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Эрчим хүчний яам	Улсын төсөв
2.	Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үндэслэн орчин үеийн дэвшилтэт техник технологи дээр ажиллах мэргэжилтэй боловсон хүчний сонгон шалгаруулалтын үндсэн дээр төрийн зардлаар урт хугацаагаар бэлтгэж, ажлын байраар хангана.	2013-2016	Сангийн яам, Хөдөлмөрийн яам	Зам, тээврийн яам, Уул, уурхайн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Эрчим хүчний яам	Улсын төсөв
3.	Эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбаруудад шаардагдах мэргэжилтэй ажилтныг ажлын байран дээр болон үйлдвэрлэл дээр тодорхой гэрээний дагуу богино хугацаанд сургаж, улмаар ажлын байраар хангах арга хэмжээг зохион байгуулна.	2013-2016	Хөдөлмөрийн яам	-	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
4.	Орчин үеийн дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж ашиглаж байгаа томоохон аж ахуйн нэгжүүдэд ажилтныг дадлагажуулан бэлтгэнэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Зам, тээврийн яам, Уул, уурхайн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Эрчим хүчний яам	Улсын төсөв
Зорилт 5. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, нийгмийн түншлэлийн байгууллагуудын идэвх санаачлагыг дэмжинэ.					
1.	Хөдөлмөрийн суурь зарчим, хөдөлмөрлөх эрхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж, хөдөлмөрийн харилцаанд шударга, тэгш байдлыг хангахад төр-хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжинэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв
2.	Хөдөлмөр эрхлэлтийн удирдлага, бодлого зохицуулалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төр-хувийн хэвшил, нийгмийн түншлэлч байгууллагуудын санал санаачлага, хамтын ажиллагааг дэмжиж, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.	2013-2016	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв
3.	Төр-хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, төрийн зарим үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хүрээг өргөжүүлэн үр дүнг сайжруулна.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Бүх яамд	Улсын төсөв
4.	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, хөдөлмөрийн харилцааны хэв шинжүүдийг төлөвшүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Улсын төсөв



5.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдлэгийг иргэд, ажилтанд олгон, энэ чиглэлийн сургалтыг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын хичээлийн хөтөлбөрт тусгана.	2014	Хөдөлмөрийн яам	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Улсын төсөв
6.	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт болон салбар, орон нутгийн түншлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар нийгмийн түншлэгчид, бусад холбогдох талуудтай хамтран ажиллаж, тэдгээрийн оролцоог хангана.	2013-2016	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв
7.	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагуудын нийгмийн хариуцлагын тогтолцоог сайжруулна.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эдийн засгийн хөгжлийн яам	Улсын төсөв
8.	Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа боловч орлого багатай, бүрэн бус хөдөлмөр эрхэлж байгаа иргэдэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд төр-хувийн хэвшлийн оролцоог хангана.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Эдийн засгийн хөгжлийн яам	Улсын төсөв
9.	Эдийн засгийн үйл ажиллагааны албан бус салбарт ажиллаж байгаа иргэдийг албан салбарт шилжүүлэх эдийн засгийн хөшүүрэг бий болгох, төрөөс дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	Сангийн яам, Хөдөлмөрийн яам	Эдийн засгийн хөгжлийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Улсын төсөв
Зорилт 6. Хүн амын хэт төвлөрлийг сааруулахад хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг чиглүүлэн, орон нутагт ажлын байр бий болгох санал, санаачлагыг дэмжиж, урамшуулна.					
1.	Орон нутагт боловсруулах үйлдвэрлэл байгуулж, байнгын ажлын байр бий болгож байгаа ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих гатвар, зээл зэрэг эдийн засгийн бусад хөшүүргийг бий болгоно.	2014	Сангийн яам, Хөдөлмөрийн яам	Эдийн засгийн хөгжлийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам,	Улсын төсөв
2.	Орон нутгийн онцлог, давуу тал, нөөц бололцоонд тулгуурлан ажлын байр бий болгох "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" дэд хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	2013-2016	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	Хөдөлмөрийн яам	Улсын төсөв
3.	Бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг дагасан хүн амын шилжих хөдөлгөөнд бэлтгэн нийгэм, эдийн засгийн цогц бодлогыг төлөвлөж, төрийн үйлчилгээний хамрах хүрээг өргөжүүлнэ.	2013-2016	Эдийн засгийн хөгжлийн яам	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	Улсын төсөв

4.	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн орон нутагт дэд бүтэц хөгжүүлэл, байгалийн нөхөн сэргээлт хийх, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үүрэг оролцоог нэмэгдүүлнэ. Нийслэлээс орон нутагт шилжин суурьших иргэдэд ажлын байр бий болгож, санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх төвлөрсөн газруудад зориулгоор Дархан, Эрдэнэт зэрэг төвлөрсөн газруудад олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлнэ.	2013-2016	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Уул уурхайн яам, Эрчим хүчний яам	Улсын төсөв
5.	Нийслэлээс орон нутагт шилжин суурьших иргэдэд ажлын байр бий болгож, санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх төвлөрсөн газруудад зориулгоор Дархан, Эрдэнэт зэрэг төвлөрсөн газруудад олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлнэ.	2013	Хөдөлмөрийн яам	Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Улсын төсөв
Зорилт 7. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгож, иргэн оршин суугаа газраасаа харьяалал үл харгалзан хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлнэ.					
1.	Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны талаархи үндсэн мэдээлэл, динамикийг агуулсан бүртгэл, мэдээллийн тогтолцоог хөгжүүлнэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Үндэсний статистикийн хороо	Улсын төсөв
2.	Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалт, жижиг, дунд үйлдвэрлэлийн асуудлаар бүртгэл, статистикийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлнэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Үндэсний статистикийн хороо	Улсын төсөв
3.	Төвлөрсөн суурин, сум, хороонд мэдээллийн сүлжээ, программ хангамж, цахим хайлтын биет системийг нэвтрүүлэх замаар хөдөлмөр эрхлэлт, ажилд зуучлалын үйлчилгээг оршин суугаа харьяалал харгалзахгүй үзүүлнэ.	2014	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв
4.	Хөдөлмөрийн хувийн биржийг хөдөлмөр эрхлэлтийн онлайн мэдээллийн системд холбож, нэгдмэл орчинд ажил зуучлалын үйлчилгээг хүргэнэ.	2014	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв
5.	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн тогтолцоог бусад салбарын мэдээллийн сангай уялдуулан, мэдээлэл солилцох, хянах, түгээх боломж бүрдүүлнэ.	2015	Хөдөлмөрийн яам	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	Улсын төсөв
Зорилт 8. Цалин хөлсний бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох замаар ажиллагчдын бүтээмж, ур чадварыг урамшуулан хөдөлмөрлөх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.					
1.	Цалин хөлсний талаар баримтлах үндэсний бодлогыг батлуулж, хэрэгжүүлнэ.	2013	Хөдөлмөрийн яам	-	-
2.	Үндэсний, бус нутгийн, салбарын болон аж ахуйн нэгжийн түвшинд бүтээмжид суурилсан цалин хөлсний зохицуулалтыг бүрдүүлнэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв
3.	Үндэсний хэмжээнд хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөн өрнүүлж, цалин хөлс, хөдөлмөрийн бүтээмжийн талаархи нийгмийн ойлголтыг нэмэгдүүлж цалин хөлс болон хөдөлмөрийн бүтээмжийн уялдаа холбоог хангах аргачлал, арга зүйг боловсронгуй болгоно.	2013-2016	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв



4.	Ажиллагчдын үндсэн цалингийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан тухай бүр индексжүүлэн нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	2014	Хөдөлмөрийн яам	Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам	Улсын төсөв
5.	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үндэсний болон бус нутаг, салбарын түвшинд тарифын хэлэлцээрээр, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хамтын гэрээ, хэлэлцээрээр ажил олгогч, ажилтны төлөөлөл хамтран тогтоож мөрдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2014	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв
Зорилт 9. Албан бус хэвшилд ажиллагчид болон хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн ажил, орлоготой болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор дор дурдсан хөдөлмөр эрхлэлтийн тусгайлсан хөтөлбөр, төслийг хэрэгжүүлнэ.					
1.	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт	2013	Хөдөлмөрийн яам	-	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
2.	Гадаадад ажиллаж, амьдарч байгаад буцаж ирсэн иргэний хөдөлмөр эрхлэлт	2013	Хөдөлмөрийн яам	-	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
3.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт	2013	Хөдөлмөрийн яам	-	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
4.	Ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт	2013	Хөдөлмөрийн яам	-	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
5.	40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлт	2013	Хөдөлмөрийн яам	-	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
6.	Тэтгэрийн насанд хүрээгүй боловч хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоологдох эрх үүсч ажилгүй болсон иргэдийн хөдөлмөр эрхлэлт	2014	Хөдөлмөрийн яам	Батлан хамгаалах яам, Уул, уурхайн яам	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
7.	Томоохон бүтээн байгуулалт, үйлдвэржилтийг дагасан хот, сууринд болон алслагдсан цэргийн ангид суурьшсан өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт	2014	Хөдөлмөрийн яам	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Батлан хамгаалах яам	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
8.	Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлт	2014	Хөдөлмөрийн яам	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
9.	Сумын төв, алслагдсан суурингийн залуучуудын хөдөлмөр эрхлэлт	2014	Хөдөлмөрийн яам	Эдийн засгийн хөгжлийн яам	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

10.	Хөнгөн ял эдэлж байгаа иргэн болон хугацаат цэргийн албан хаагчийг хөдөлмөрт бэлтгэнэ. Зорилт 10. Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан боловсронгуй болгоно.	2013	Хөдөлмөрийн яам	Батлан хамгаалах яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
1.	Эдийн засгийн салбарт хэрэгцээтэй байгаа ажиллах хүчийг гадаадаас авахад тавигдах мэргэжил, боловсрол, эрүүл мэндийн шалгуурыг боловсронгуй болгоно.	2013	Хөдөлмөрийн яам	Эрүүл мэндийн яам	Улсын төсөв
2.	Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаадын иргэний ажлын байрны төлбөрийг салбарын онцлог, дотоодын ажиллах хүчний нийлүүлэлттэй уялдуулан уян хатан тогтоож, улмаар үндэсний ажиллах хүчийг тогтоосон квотын дагуу сургаж, дэдлагажуулахад дэмжлэг үзүүлнэ.	2013	Хөдөлмөрийн яам	-	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
3.	Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдсөн болон ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байууллага нь квот, заасан хугацаа зөрчсөн тохиолдолд ажлын байрны төлбөрийг тогтоосон хэмжээнээс нэмэгдүүлэн нөхөн төлөх зэргээр хариуцлагын тогтолцоог чангатгана.	2013	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв
4.	Гадаадад ажиллах хүч зуучлах үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгож, зуучлах үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх, Монгол Улсын иргэд гадаадад хөдөлмөрлөхтэй холбоотой эрхийг хангахад дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв
5.	Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа монгол иргэдийг мэргэшүүлэн, тухайн улсаас олгосон мэргэжил, ур чадварын гэрчилгээг хүлээн зөвшөөрөх тогтолцоог бий болгоно.	2013	Хөдөлмөрийн яам	-	Улсын төсөв
6.	Гадаадад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийн эрх ашиг, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамгаалж, эрх зүйн зөвлөгөө өгөх, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах зэрэг ажлыг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Гадаад харилцааны яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	Улсын төсөв
7.	Гадаадад ажиллаж, амьдарч байгаад буцаж ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, бизнес инкубацийн үйлчилгээнд хамруулах, өндөр хөгжилтэй орнуудын дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	Хөдөлмөрийн яам	Сангийн яам	Улсын төсөв



Зорилт 11. Нийтийн эрх ашгийг хангах, ногоон хөгжлийн үйл ажиллагаанд ажилгүй иргэн, хөдөлмөрлөх боломжтой хүн амыг хамруулан орлогоор дэмжинэ.

1.	2013	Хөдөлмөрийн яам	-	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
"Эзэнтэй Монгол" хөтөлбөрийн хүрээнд байгалийн аюулт үзэгдэл, доройтол, гамшгийн үр дагаврыг арилган, нөхөн сэргээх үйл ажиллагааг ажил эрхлээгүй, ажил эрхлэх боломжтой иргэдийг оролцуулан зохион байгуулж, орлогоор дэмжинэ.	2013	Хөдөлмөрийн яам	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Барилга, хот байгуулалтын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Зам тээврийн яам, Эрүүл мэндийн яам	Улсын төсөв
2.	2014	Хөдөлмөрийн яам		Улсын төсөв
3.	2013	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	Хөдөлмөрийн яам	Улсын төсөв

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turin\_medelele@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3.25

**Индекс: 14003**